



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/160

Есөнбулаг сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Аймгийн 2026 оны төсөв батлах" 64 дүгээр тогтоол, Үнэлгээний хорооны 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 174 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх ГААХААГ/20260101006 дугаартай "Тайшир сумын цэвэрлэх байгууламжийн угсралт, суурилуулалт, тохируулгын ажил"-ыг "Хонгор буурал" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т олгосугай.

2. Тендерийн баримт бичигт ирүүлсэн ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

